БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/169/НА-СТА-ТШЗ**

---


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2022 он

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ ........ 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ........ 10
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
4.1 Залруулсан алдаа ........ 16
4.2 Албан шаардлага ........ 16
4.3 Зөвлөмж ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022. 02. 16 № 2/14

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БАТ-ОРШИХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.



0050?0?10

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **409,269,795.11** | **354,855,023.11** |
| **33** | **АВЛАГА** | 46,536,823.00 | 4,592.00 |
| **335** | **Бусад авлага** | 46,536,823.00 | 4,592.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 44,161,823.00 | 4,592.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,375,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 362,732,972.11 | 354,850,431.11 |
| **351** | **Түүхий эд материал** | 258,631,883.61 | 246,497,522.61 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 257,812,983.61 | 246,497,522.61 |
| 35130 | Эм боох материал | 818,900.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 104,101,088.50 | 108,352,908.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,468,980.00 | 9,945,080.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 63,488,088.50 | 61,980,788.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,248,000.00 | 2,308,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 18,791,800.00 | 19,294,900.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,291,220.00 | 5,235,340.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,813,000.00 | 9,588,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,602,572,684.40** | **2,996,010,031.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,602,572,684.40 | 2,996,010,031.89 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,814,464,350.95 | 2,214,910,031.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,426,273,117.61 | 2,068,208,664.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (286,814,915.13) | (436,157,448.05) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 167,364,900.00 | 167,364,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (118,762,185.00) | (132,648,675.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,724,140,162.02 | 1,772,791,190.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,221,351,595.26) | (1,333,933,076.90) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 193,459,497.39 | 194,609,497.39 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (156,177,754.51) | (166,884,715.41) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,878,953.00 | 19,378,953.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (19,282,079.07) | (18,828,954.07) |
| 39217 | Ном | 85,736,249.90 | 81,009,695.90 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 788,108,333.45 | 781,100,000.00 |
| 39301 | Программ хангамж | 18,010,735.00 | 1,760,735.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (11,002,401.55) | (1,760,735.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 781,100,000.00 | 781,100,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,011,842,479.51** | **3,350,865,055.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,011,842,479.51** | **3,350,865,055.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,011,842,479.51 | 3,350,865,055.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,945,234,164.54 | 1,945,234,164.54 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,945,234,164.54 | 1,945,234,164.54 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (404,571,397.22) | (65,548,821.73) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (351,895,218.03) | (404,571,397.22) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (52,676,179.19) | 339,022,575.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,471,179,712.19 | 1,471,179,712.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,011,842,479.51** | **3,350,865,055.00** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,488,111,500.00** | **2,833,458,659.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **321,685,900.00** | **726,304,959.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 321,685,900.00 | 726,304,959.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 321,685,900.00 | 726,304,959.40 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,014,860.00 | 8,542,935.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,076,000.00 | 1,480,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 310,595,040.00 | 716,282,024.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,166,425,600.00** | **2,107,153,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,160,400,100.00 | 2,079,119,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,160,400,100.00 | 2,079,119,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,540,787,679.19** | **2,481,900,943.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,540,787,679.19** | **2,481,900,943.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,183,809,987.39 | 2,279,793,710.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,174,473,921.33 | 1,216,817,868.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,172,414,261.33 | 1,216,817,868.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,059,660.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 145,277,618.87 | 158,606,157.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 145,277,618.87 | 158,606,157.35 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 343,645,059.00 | 429,563,432.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,677,447.00 | 9,162,740.00 |
| 210302 | Түлш, халаалт | 311,819,300.00 | 400,952,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,148,312.00 | 19,448,692.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,583,321.00 | 28,421,976.51 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,140,134.00 | 3,739,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,359,877.00 | 5,313,431.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,159,477.00 | 4,514,445.51 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,647,400.00 | 960,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,952,750.00 | 13,895,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,323,683.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 25,600,440.00 | 24,884,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 187,500.00 | 1,138,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,011,940.00 | 15,594,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,401,000.00 | 8,151,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,768,850.00 | 13,586,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,768,850.00 | 13,586,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 640,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 640,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,353,943.00 | 14,492,755.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,381,470.00 | 3,102,755.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,082,473.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,890,000.00 | 9,890,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 446,466,834.19 | 393,420,322.09 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 91,223,447.40 | 79,927,786.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 355,243,386.79 | 313,492,536.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 356,977,691.80 | 202,107,232.14 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 121,730,580.00 | 149,535,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,608,900.00 | 68,210,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 107,513,200.00 | 81,325,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,608,480.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 235,247,111.80 | 52,571,432.14 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 235,247,111.80 | 52,571,432.14 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(52,676,179.19)** | **351,557,716.31** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 12,535,140.82 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 12,535,140.82 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (12,535,140.82) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(52,676,179.19)** | **339,022,575.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,180,949,460.00** | **2,119,551,635.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,523,860.00** | **12,397,935.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 14,523,860.00 | 12,397,935.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 14,523,860.00 | 12,397,935.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,057,860.00 | 10,917,935.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,466,000.00 | 1,480,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,166,425,600.00** | **2,107,153,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,160,400,100.00 | 2,079,119,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,160,400,100.00 | 2,079,119,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,025,500.00 | 28,034,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,170,899,460.00** | **2,108,104,735.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,170,899,460.00** | **2,108,104,735.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,813,671,768.20** | **1,904,423,102.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,173,097,260.33 | 1,216,817,868.00 |
| 210101 | Үндсэн цалин | 775,484,538.97 | 770,755,059.00 |
| 210102 | Нэмэгдэл | 268,421,588.37 | 302,558,317.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 50,259,797.94 | 51,034,401.90 |
| 210104 | Урамшуулал | 78,931,335.05 | 92,470,090.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 145,277,618.87 | 158,606,157.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,406,624.78 | 111,080,280.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,349,072.01 | 12,260,339.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,879,316.67 | 9,744,431.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,420,545.45 | 2,317,325.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,222,059.96 | 23,203,780.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 387,666,759.00 | 385,541,732.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,677,447.00 | 9,162,740.00 |
| 210302 | Түлш, халаалт | 355,841,000.00 | 356,930,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,148,312.00 | 19,448,692.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,583,177.00 | 25,600,645.51 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,432,879.00 | 2,654,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,310,000.00 | 2,920,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,170,798.00 | 4,514,445.51 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,000,000.00 | 2,700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,669,500.00 | 12,811,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,741,500.00 | 22,296,620.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 850,400.00 | 320,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,996,100.00 | 14,840,620.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,895,000.00 | 7,136,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 9,428,900.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 9,428,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 640,000.00 | 512,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 640,000.00 | 512,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,353,943.00 | 14,492,755.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,381,470.00 | 3,102,755.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,082,473.00 | 1,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,890,000.00 | 9,890,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,311,510.00 | 71,126,425.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 49,311,510.00 | 71,126,425.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **357,227,691.80** | **203,681,632.14** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 121,980,580.00 | 151,110,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,608,900.00 | 68,210,600.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 107,513,200.00 | 81,325,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,858,480.00 | 1,574,400.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 235,247,111.80 | 52,571,432.14 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 235,247,111.80 | 52,571,432.14 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 10,050,000.00 | 11,446,900.00 |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,050,000.00** | **11,446,900.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,050,000.00** | **11,446,900.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 10,050,000.00 | 11,446,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,050,000.00 | 11,446,900.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | (10,050,000.00) | (11,446,900.00) |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,945,234,164.54 | 1,471,179,712.19 | -404,571,397.22 | 0.00 | 3,011,842,479.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-404,571,397.22** | **0.00** | **3,011,842,479.51** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-404,571,397.22** | **0.00** | **3,011,842,479.51** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-404,571,397.22** | **0.00** | **3,011,842,479.51** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-404,571,397.22** | **0.00** | **3,011,842,479.51** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 339,022,575.49 | 0.00 | 339,022,575.49 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-65,548,821.73** | **0.00** | **3,350,865,055.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,110,119,700.00 | 2,038,946,527.86 | (71,173,172.14) | 96.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,110,119,700.00 | 2,038,946,527.86 | (71,173,172.14) | 96.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,959,009,500.00 | 1,887,836,327.86 | (71,173,172.14) | 96.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,249,628,800.00 | 1,216,817,868.00 | (32,810,932.00) | 97.4 |
| 210101 | Үндсэн цалин | 797,788,500.00 | 770,755,059.00 | (27,033,441.00) | 96.6 |
| 210102 | Нэмэгдэл | 316,216,700.00 | 302,558,317.10 | (13,658,382.90) | 95.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,084,000.00 | 51,034,401.90 | (49,598.10) | 99.9 |
| 210104 | Урамшуулал | 84,539,600.00 | 92,470,090.00 | 7,930,490.00 | 109.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 175,449,900.00 | 158,606,157.35 | (16,843,742.65) | 90.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 123,464,700.00 | 111,080,280.21 | (12,384,419.79) | 90.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,996,300.00 | 12,260,339.57 | (735,960.43) | 94.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,397,000.00 | 9,744,431.99 | (652,568.01) | 93.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,599,300.00 | 2,317,325.34 | (281,974.66) | 89.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,992,600.00 | 23,203,780.24 | (2,788,819.76) | 89.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 395,835,900.00 | 385,541,732.00 | (10,294,168.00) | 97.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,985,400.00 | 9,162,740.00 | (3,822,660.00) | 70.6 |
| 210302 | Түлш, халаалт | 361,448,100.00 | 356,930,300.00 | (4,517,800.00) | 98.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,402,400.00 | 19,448,692.00 | (1,953,708.00) | 90.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,166,200.00 | 27,165,645.51 | (554.49) | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,654,000.00 | 2,654,000.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,920,300.00 | 2,920,300.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,080,000.00 | 6,079,445.51 | (554.49) | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,700,000.00 | 2,700,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,811,900.00 | 12,811,900.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,495,000.00 | 22,296,620.00 | (11,198,380.00) | 66.6 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 350,400.00 | 320,000.00 | (30,400.00) | 91.3 |
| 210502 | Хоол, хүнс | 26,008,600.00 | 14,840,620.00 | (11,167,980.00) | 57.1 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,136,000.00 | 7,136,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,429,000.00 | 9,428,900.00 | (100.00) | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,429,000.00 | 9,428,900.00 | (100.00) | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 512,000.00 | 512,000.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 512,000.00 | 512,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,514,800.00 | 14,492,755.00 | (22,045.00) | 99.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,124,800.00 | 3,102,755.00 | (22,045.00) | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,890,000.00 | 9,890,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,977,900.00 | 52,974,650.00 | (3,250.00) | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 52,977,900.00 | 52,974,650.00 | (3,250.00) | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 151,110,200.00 | 151,110,200.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 151,110,200.00 | 151,110,200.00 | - | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 68,210,600.00 | 68,210,600.00 | - | 100.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,325,200.00 | 81,325,200.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,574,400.00 | 1,574,400.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,110,119,700.00** | **2,038,946,527.86** | **(71,173,172.14)** | **96.6** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,079,119,700.00 | 2,026,548,592.86 | (52,571,107.14) | 97.5 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,079,119,700.00 | 2,026,548,592.86 | (52,571,107.14) | 97.5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **31,000,000.00** | **12,397,935.00** | **(18,602,065.00)** | **40.0** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,500,000.00 | 10,917,935.00 | (14,582,065.00) | 42.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,500,000.00 | 1,480,000.00 | (4,020,000.00) | 26.9 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **-** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **96.00** | **96.00** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 4.00 | 4.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 74.00 | 74.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **991.00** | **991.00** | **-** | **100.0** |
| **632** | **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ** | 991.00 | 991.00 | - | 100.0 |
| 632001 | Төрийн өмчит МСҮТ | 991.00 | 991.00 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,025,500.00** | **28,034,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,025,500.00** | **28,034,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,025,500.00 | 28,034,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,025,500.00** | **28,034,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,025,500.00** | **28,034,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,025,500.00 | 28,034,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэзнзм, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Д.Бат-Орших, 2 дугаар гарын үсгийг Ц.Цэвээнсүрэн нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

ЗОРИЛГО:

- Судалгаа шинжилгээ, инновац, мэдээллийн технологид суурилсан сургалтын чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэх

ЗОРИЛТ:

- Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн, бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн мэргэжилтэй ажилтныг бэлтгэнэ.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, цахим сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх, цахим үнэлгээ, дижитал технологийн арга зүйг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.
- Суралцагчийн бүх талын хөгжил, хамгаалал, төлөвшлийн асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай хамтран тэдний үүрэг хариуцлага, идэвх оролцоог нэмэгдүүлнэ.
- Төсөл хөтөлбөр, нийгмийн түншлэл, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Сургалт үйлдвэрлэлийн зардал, материалын нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлнэ.
- Багш, ажилтан, ажиллагсдын сахилга, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг сахиулах

ЧИГ ҮҮРЭГ:

Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, нөхцөл шаардлагыг мөрдөж, тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн чиглэл, түвшний боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын ажил эрхлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөрийн яамны дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,540,787.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,407.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,785.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 17,373.3 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 339,022.6 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 409,269.8 | 354,855.0 | (54,414.8) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 46,536.8 | 4.6 | (46,532.2) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 362,733.0 | 354,850.4 | (7,882.5) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,602,572.7 | 2,996,010.0 | 393,437.3 |
| Үндсэн хөрөнгө | 4,415,963.6 | 5,086,223.6 | 670,260.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,813,390.9) | (2,090,213.6) | (276,822.7) |
| **Нийт хөрөнгө** | **3,011,842.5** | **3,350,865.1** | **339,022.6** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,011,842.5 | 3,350,865.1 | 339,022.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,011,842.5** | **3,350,865.1** | **339,022.6** |

Авлагын данс дансны үлдэгдэл 4.6 мянган төгрөг болж 46,532.2 мянган төгрөгөөр буурсан нь бусад тооцооны авлага буюу “Марал гүн” ХХК-аас авах авлагыг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022.01.10-ний 3/47 тоот албан бичгээр 2019 оны халаалтын зардлын өглөгийг 2020 оны төсөвт батлагдсан талаар албан бичиг ирүүлж авлагыг хорогдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 354,850.4 мянган төгрөг болж 7,882.5 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал 6,775.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын материал 11,315.5 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,086,223.6 мянган төгрөг болж 670,260.0 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хөрөнгө оруулалтаар 625,786.3 мянган төгрөгийн авто засварын дадлагын байр ашиглалтад орсон нь голлох дүнг эзэлж байна. Мөн тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 524 тоот тогтоолоор 49,205.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,350,865.1 мянган төгрөг болж 339,022.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,393,550.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,413,550.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 303,430.4 мянган төгрөгөөр бууруулж 2,110,119.7 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Санал хүргүүлсэн зардлаас цалингийн зардлыг 145,059.8 мянга, ЭМНДШ-ийг 25,112.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 28,647.6 мянга, норматив зардлыг 145,373.4 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,110,119.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,079,119.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,079,119.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 12,397.9 мянган төгрөг оруулж урсгал үйл ажиллагаанд 2,038,946.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 52,571.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,038,946.5 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа бөгөөд нийт орлогын төлөвлөгөө биелээгүйгээс 18,602.1 мянган төгрөгөөр орлого тасарсан бол тайлант онд цалингийн зардал 32,810.9 мянга, ЭМНДШ-ийн зардал 16,843.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10,294.2 мянга, номрматив зардал 11198.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг дэмжих сургалтын 12,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, “Эрдэнэ Монгол” ХХК-аас 16,034.0 мянган төгрөгийн түр сургалт зохион байгуулах зардлыг авч сургалтыг зохион байгуулж тухайн 28,034.0 мянган төгрөгийг сургалтын цалин, дадлага, дадлагын материал зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 47 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 91.7 хувьтай дүгнэгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,481,900.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 58,886.7 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон тэтгэмжийн зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 149 | 0 | 2 |

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

буюу төсвийн 3.7 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй өгсөн 28,985.7 мянган төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**
Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 90,989.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,157.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 87,832.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, тэтгэвэрт гарсан албан хаагч ажиллуулж байгаад 1 зөвлөмж хүргүүллээ.

**4.1 Залруулсан алдаа**

1 Хичээл практикийн зардлаас түр сургалт зохион байгуулсан 3,157.3 мянган төгрөгийн цалингийн зардлыг үр дүнгийн тайланд цалингийн зардлаар илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн тайланд цалингийн зардлаас хичээл практикийн зардал руу 3157.3 мянган төгрөгөөр залруулга хийв.

**4.2 Албан шаардлага**

1.1. Түр сургалтын даллагын үр дүнд бий болсон 4,411.4 мянган төгрөгийн үнэ бүхий бүхий явган хүний замыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түр сургалтын үр дүнд бий болсон 4411.4 мянган төгрөгийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн хэмжээг тогтоож, хөрөнгийн бүртгэлд бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

1.2. Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хөрөнгө оруулалтаар 625,786.3 мянган төгрөгийн авто засварын дадлагын байр ашиглалтад орсон бөгөөд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгө бүртгэх зөвшөөрөл авар хүсэлт явуулахдаа гадна тохижилтын 26108.7 мянга, гадна шугам сүлжээний 57,312.3 мянган төгрөгийг орхигдуулан 542,365.3 мянган төгрөгөөр шийдвэр гаргуулж нийт 83,421.0 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэр гаргуулалгүй орлогод бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэргүй бүртгэсэн 83,421.0 мянган төгрөгийн хөрөнгийн шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлан нөхөн гаргуулах албан шаардлагыг төсөв захирагчид хүргүүлэв.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1.1. Илрүүлэлт:*

2021 онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгож, өндөр насны тэтгэвэрт гарсан 2 багшийг ажлаас чөлөөлөгдсөн өдрийн дараагийн өдрөөс түр тушаалаар авч ажиллуулж 7703.8 мянган төгрөгийн зардал гарсан байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан албан хаагчийн орон тоонд ажиллах хүний нөөцийн бодлогыг оновчтой зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянхонгор аймгийн Политехникийн коллеж | 4 | 90,989.7 | 1 | 3,157.3 | 0 | 0 | 2 | 87,832.4 | 1 | 7,703.8 |

______oOo______